



## “АЛТАНБУЛАГ” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

“Алтанбулаг” чөлөөт бүс нь Ази Европийг холбосон стратегийн ач холбогдол бүхий АН-3 замын зангилаа хэсэг, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт оршдог.

Монгол улсад “Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал”-ыг 1995 онд баталж, улмаар “Чөлөөт бүсийн тухай”, “Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай” хуулиудийг 2002 онд, “Чөлөөт бүсийн тухай” хуулийн шинэчилсэн найруулга 2015 онд тус тус батлагдан хэрэгжиж байна.

“Алтанбулаг” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу 2004-2012 онуудад 26,5 тэрбум төгрөгний улсын төсвийн хөрөнгө оруулалт хийгдэж

- Чөлөөт бүсийн сайжруулсан шороон авто замын ажил
- Цахилгаан дамжуулах агаарын түр шугам
- Үерийн хамгаалалтын далан сувгийн ажил -/9,4км/
- Бүсийн гадна болон доторхи цэвэр усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ-/36км/
- 800м3 усан сан

зэрэг дэд бүтцийн ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

“Алтанбулаг” чөлөөт бүс нь 2014 онд Засгийн газрын 153 дугаар тогтоолоор нээгдэж, үйл ажиллагааны байнгын дэглэмд шилжин ажилласнаар чөлөөт бүсийн гадаад, дотоодын хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалтын хэмжээ, тэдгээрийн хамрах цар хүрээ өдрөөс өдөрт өргөжин тэлсээр байна.

“Алтанбулаг” чөлөөт бүсийн хууль, эрх зүйн орчинг сайжруулах ажлын хүрээнд “Чөлөөт бүсийн тухай” хуулийн 16.2 дахь заалтын дагуу **Засгийн газрын 2020 оны 105 дугаар тогтоолоор “Чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх зорчигчийн худалдаж авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааны нэр төрлийн жагсаалт”-ыг батлуулж, улмаар Гаалийн ерөнхий газрын “Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам”-ын 5.1.1-5.1.7 заалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан.** Ингэснээр:

- “Чөлөөт бүсийн тухай” хуулийн 16.1.4 дэх заалт нь “Хүнсний тухай хууль”-ийн 11 дүгээр зүйлийн 11.1. “Хүнсийг зөвхөн Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд экспортолж, импортолно.” гэсэн заалттай өөр хоорондоо зөрчилдөж байсан нь зохицуулагдаж, хууль хоорондын уялдаа холбоо сайжирсан.
- Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/223 дугаар тушаалаар баталсан “Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам”-ын 2.3.1-д заасан барааг зорчигч чөлөөт бүсээс хоногт нэгээс илүүгүй удаа

гаалийн болон бусад татваргүйгээр гаалийн нутаг дэвсгэрт оруулах эрх зүйн нөхцөл боломжууд тус тус бүрдсэн.

Хууль, эрх зүйн орчин сайжирснаар хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдийн барааны нэр төрөл, тоо хэмжээ нэмэгдэн иргэд зорчигчдын барааны сонголт болон худалдан авалт өссөн.

2008 оноос хойш чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт газар эзэмших эрх нь цуцлагдсан 231 аж ахуйн нэгжийн газрын төлбөрийн болох нийт 1.177.086.220 төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд 2018 оноос эхлэн авлагыг барагдуулах талаар шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр нэхэмжлэл гаргаж 2019 онд 809.898.660 төгрөг, 2020 онд 423.999.170 төгрөг, 2021 оны хагас жилийн байдлаар 345,225,228.12 төгрөг хүртэл тус тус бууруулан ажилласан байна.

2002 оноос эхлэн төсвийн болон хувийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудыг гүйцэтгэх явцад түр ажлын байр 716 гаруй, байнгын ажлын байр 60-аад бий болоод байна.

- Чөлөөт бүсэд газар эзэмшүүлэх, ашиглах **төсөл сонгон шалгаруулалтыг** 2015-2020 онуудад 7 удаа явуулж, 9 ААН шалгарч 5 ААН гэрээ байгуулсан.

- Чөлөөт бүсэд анх удаа газар эзэмших, ашиглах **дуудлага худалдааг** 2021.09.02-ны өдөр зохион байгуулсан. 9 ААН ялагчийн гэрээ байгуулж 456.3 сая төгрөг төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн.

2014-2021 онуудад 20 гаруй хөрөнгө оруулагч, аж ахуйн нэгж байнгын үйл ажиллагаа явуулж, чөлөөт бүсэд хүнсний бараа, техник тоног төхөөрөмж, гэр ахуй, гоо сайхан, спорт бараа болон бэлэн хувцас зэрэг давхардсан тоогоор 100 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг ОХУ, БНКазахстан, БНУзбекистан, БНКиригиз,АНЭУ, Голланд, Чили, Аргентин, ХБНГУ, Итали, Дани, БНХАУ, БНСУ улсуудаас импортлон худалдаалж байна.

2015-2020 онуудад чөлөөт бүсэд бараа эргэлт 4.5 дахин, мөн чөлөөт бүсээр нэвтэрсэн зорчигч 5.5 дахин, тээврийн хэрэгслийн статистик тоо 6,3 дахин өссөн үзүүлэлттэй.

Дэлхий даяар короновирусын халдвар, цар тахал хэлбэрээр түгэн тархаж байгаа энэхүү онц байдлын үед “Алтанбулаг” чөлөөт бүс нь Улсын онцгой комисс, Аймгийн онцгой комиссоос гаргасан шийдвэрүүдийн дагуу зохицуулалтыг хийж, Алтанбулаг сумын зорилтот бүлгийн иргэдэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдээс 4,1 сая төгрөгний тусламжийг үзүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан. Мөн сум, орон нутгийн үйл ажиллагааг дэмжин хариуцлагатай эргүүл жижүүрийн ажлыг гүйцэтгэж байна.

## **“АЛТАНБУЛАГ” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД ШИЙДВЭРЛЭХ АСУУДЛУУД**

НЭГ. “Алтанбулаг” чөлөөт бүсэд 2002-2012 онуудад 26.5 тэрбум төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалт хийгдсэн бөгөөд үүнээс хойш хөрөнгө оруулалт хийгдээгүй байна. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан доорхи ажлуудыг 2022 оны улсын төсөвт тусгуулж батлуулах шаардлагатай байна. Үүнд:

- Алтанбулаг чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх.
- **Бүсийн болон аймаг, сумын доторх цахилгаан хангамжийг өргөтгөх Батлагдсан зураг, 15.6 тэрбум төгрөгний төсөвт өртөгтэй.**
- “Алтанбулаг” чөлөөт бүсийг Гаалийн теле хяналтын нэгдсэн системд холбох /130 сая төгрөг/

ХОЁР. Улсын комисст хүлээлгэн өгсөн чөлөөт бүсийн гаднах дэд бүтцийн барилга байгууламжууд /ариутгах татуургын болон цэвэр усны шугам хоолой/-ыг аймаг, орон нутгийн мэргэжлийн байгууллагуудад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэж ашиглалтын зардлыг тус аймгийн 2022 оны төсөвт тусгах.

ГУРАВ. Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан “Алтанбулаг” чөлөөт бүсийн доторх 14.6 км хатуу хучилттай авто замын барилга угсралтын ажил болон тээвэр, логикийн төв бариулах ажлын санхүүжилтыг шийдвэрлүүлэх шаардлагатай байна. /Монгол улсын Шадар сайдын ажлын алба, Зам, тээврийн хөгжлийн яам, Азийн хөгжлийн банк/.

ДӨРӨВ. Монгол Улс, ОХУ-ын хил орчмын бүс нутгийн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, худалдаа, үйлчилгээг эрчимжүүлэх хүрээнд Худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комисс болон Дэд комиссын хуралдаануудад “Алтанбулаг” чөлөөт бүсээс саналуудыг жил бүр тусгуулдаг боловч тэдгээр асуудлууд шийдвэрлэгддэггүй.

“Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэл”-ийн хүрээнд “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс” болгох тухай Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах.

**“АЛТАНБУЛАГ” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА**